



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/174/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот</p> <p>2021 он</p>	<p>Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БӨӨНЦАГААН ОРОГ НУУРЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ХҮРЭЛСҮХ ТАНАА

2021.02.03 № 2/13
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР /  Б.МӨНХБАТ



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,458,198.00	17,249,075.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,458,198.00	17,249,075.00
351	Түүхий эд материал	4,177,500.00	9,615,880.00
35110	Тусгай зориулалттай материал	4,177,500.00	9,615,880.00
354	Хангамжийн материал	9,280,698.00	7,633,195.00
35410	Бичиг хэргийн материал	335,000.00	839,000.00
35420	Аж ахуйн материал	3,847,498.00	3,785,397.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,108,100.00	215,000.00
35440	Түлш, шатах тослох материал	905,100.00	2,708,798.00
35470	Бусад хангамжийн материал	85,000.00	85,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22,012,189.92	20,039,434.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,012,189.92	20,039,434.46
392	Биет хөрөнгө	22,012,189.92	20,039,434.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,896,000.00	33,855,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		28,889,332.91	31,896,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,361,866.00	49,435,766.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		31,424,598.82	36,138,398.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,856,884.39	12,856,884.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,788,628.74	-8,074,317.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	195,000.00	195,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-195,000.00	-195,000.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	35,470,387.92	37,288,509.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	265,030.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	265,030.00	00.00
413	Өглөг	265,030.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	184,130.00	00.00
4136	Бусад өглөг	80,900.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	80,900.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	35,205,357.92	37,288,509.46
51	Засгийн газрын хувь оролцоо	35,205,357.92	37,288,509.46
512	Хуримтлагдсан үр дүн	35,205,357.92	37,288,509.46
51210	Өмнөх үеийн үр дүн	35,205,357.92	35,205,357.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,083,151.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	35,470,387.92	37,288,509.46

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	164,434,286.00	201,450,407.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	12,181,621.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	12,181,621.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	12,181,621.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	223,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	11,957,721.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,434,286.00	189,268,786.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	152,805,600.00	178,404,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,805,600.00	178,404,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,628,686.00	10,864,286.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,428,686.00	714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	150,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	168,982,014.96	199,367,255.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,982,014.96	199,367,255.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,510,447.96	170,260,430.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,739,084.00	107,186,744.00
210101	Үндсэн цалин	89,739,084.00	107,186,744.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,436,910.00	14,168,792.29
210201	Тэтгэврийн даатгал	11,436,910.00	10,393,706.12
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,162,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	993,930.70
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	249,833.18
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,368,422.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,948,000.00	8,947,000.00
210304	Байрны түрээс	8,948,000.00	8,947,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,391,896.00	15,273,789.00
210401	Бичиг хэрэг	1,622,400.00	2,474,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,355,400.00	8,015,193.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	903,796.00	1,148,096.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	510,300.00	2,648,800.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	987,500.00
2105	Норматив зардал	00.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	100,000.00

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	956,500.00	7,088,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	695,400.00
210604	Урсгал засвар	956,500.00	6,393,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,278,000.00	3,094,500.00
210702	Дотоод албан томилолт	2,278,000.00	3,094,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,460,700.00	5,394,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,674,000.00	4,740,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,300.00	86,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	355,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,299,357.96	9,006,155.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,299,357.96	9,006,155.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,471,567.00	29,106,824.71
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,471,281.00	29,020,538.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,471,281.00	29,020,538.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	286.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	286.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	86,286.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	86,286.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4,547,728.96	2,083,151.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,547,728.96	2,083,151.54

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	164,515,186.00	189,492,686.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,900.00	223,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	80,900.00	223,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,900.00	223,900.00
1200042	Туслах үйл-ажиллагааны орлогоос санхүүжих	80,900.00	223,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,434,286.00	189,268,786.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	152,805,600.00	178,404,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,805,600.00	178,404,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,628,686.00	10,864,286.00

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,428,686.00	714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	150,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	164,126,186.00	188,853,786.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,126,186.00	188,853,786.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,654,905.00	159,746,961.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,199,195.00	105,548,923.63
210101	Үндсэн цалин	67,177,448.00	83,094,628.63
210102	Нэмэгдэл	15,335,347.00	15,849,295.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,686,400.00	6,605,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,488,669.00	14,493,935.66
210201	Тэтгэврийн даатгал	7,237,069.00	9,991,935.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,162,900.00	1,242,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	930,400.00	993,930.70
210204	Ажилгүйдлийн даатгал	232,500.00	248,500
210205	Эрүүл мэндийн даатгал	1,925,800.00	2,016,869.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,948,000.00	8,947,000.00
210304	Байрны түрээс	8,948,000.00	8,947,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,514,441.00	11,252,496.00
210401	Бичиг хэрэг	1,356,941.00	1,508,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,117,200.00	5,647,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	887,500.00	1,448,096.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,152,800.00	2,648,700.00
2105	Норматив зардал	624,000.00	624,499.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,000.00	624,499.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,883,500.00	2,856,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	249,900.00	2,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	355,500.00	356,400.00
210604	Урсгал засвар	1,278,100.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,582,000.00	3,094,500.00
210702	Дотоод албан томилолт	2,582,000.00	3,094,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,415,100.00	12,929,207.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,628,400.00	12,274,807.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,300.00	86,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	355,000.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,471,281.00	29,106,824.71

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,471,281.00	29,020,538.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,471,281.00	29,020,538.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	86,286.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	86,286.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	389,000.00	638,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	389,000.00	638,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	389,000.00	638,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	389,000.00	638,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	389,000.00	638,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-389,000.00	-638,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	35,205,357.92	00.00	35,205,357.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	35,205,357.92	00.00	35,205,357.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,083,151.54	00.00	2,083,151.54
D09	2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	00.00	00.00	37,288,509.46	00.00	37,288,509.46

2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	178,404,500.00	149,607,861.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,404,500.00	149,607,861.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,404,500.00	149,607,861.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,262,500.00	105,548,923.63
210101	Үндсэн цалин	86,448,200.00	83,094,628.63
210102	Нэмэгдэл	31,127,900.00	15,849,295.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,686,400.00	6,605,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,775,400.00	14,493,935.66
210201	Тэтгэврийн даатгал	11,804,900.00	9,991,935.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,242,700.00	1,242,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	994,000.00	993,930.70
210204	Ажилгүйдлийн даатгал	248,500.00	248,500
210205	Эрүүл мэндийн даатгал	2,485,300.00	2,016,869.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,949,300.00	8,947,000.00
210304	Байрны түрээс	8,949,300.00	8,947,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,291,600.00	11,252,496.00
210401	Бичиг хэрэг	1,508,600.00	1,508,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,647,500.00	5,647,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,482,700.00	1,448,096.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,652,800.00	2,648,700.00
2105	Норматив зардал	624,500.00	624,499.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,500.00	624,499.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,495,300.00	3,495,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,138,900.00	3,138,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	356,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,172,500.00	3,094,500.00
210702	Дотоод албан томилолт	3,172,500.00	3,094,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,833,400.00	2,151,207.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	1,496,807.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	86,400.00

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	59,400.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	177,731,700.00	149,607,861.29
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	177,731,700.00	149,383,961.29
131001	Улсын төсвөөс санхүүжих	177,731,700.00	149,383,961.29
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	223,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	223,900.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	10.00	08.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	06.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10.00	08.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	07.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	01.00	01.00

2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11628686.00	10691714.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11628686.00	10691714.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11628686.00	10691714.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11628686.00	10691714.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11628686.00	10,691,714.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11628686.00	10778000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11628686.00	10,778,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,428,686.00	714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	150,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Хүрэлсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав

Аудитыг 2021.01.29-ноос 2021.02.01-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.10.26-ны өдрийн 161 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сав газрын усны нөөцөд түшиглэн орон нутгийн болон салбаруудын хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдсан, усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэн байгаль орчны унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, нөхцөлийг бүрдүүлж, нийгэм эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангана.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2018, 2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт шалгалтыг хийж зөрчил 10 заалт бүхий зөвлөмж, 635,6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 170450,1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3409,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 199367,3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3987,3 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1818.1 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,458.2	17,249.1	3,790.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	13,458.2	17,249.1	3,790.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22,012.2	20,039.4	(1,972.8)
Үндсэн хөрөнгө	90,079.8	97,113.2	7,033.4
Хуримтлагдсан элэгдэл	(68,067.6)	(77,073.7)	(9,006.2)
Нийт хөрөнгө	35,470.4	37,288.5	1,818.1
Өр төлбөр	265.0	-	(265.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	35,205.4	37,288.5	2,083.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	35,470.4	37,288.5	1,818.1

Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авав/

Бараа материалын дансны үлдэгдэл 17249.1 мянган төгрөг болж 3790.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 5438,4 мянга төгрөг болж өссөнтэй холбоотой байна.

Энэ нь аймгийн Байгаль орчин аялал жуулчлал газраас авч өгсөн “Усны чанар шалгагч” бодис худалдан авч зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 97113,1 мянган төгрөг болж 7033,4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 638,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4435,0 усны чанар шалгагч багаж, БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар 1959,5 мянган төгрөгийн мотоциклийг шилжиж ирсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 37288,5 мянган төгрөг болж 2083,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 2083,1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 201450,4 мянган төгрөг болж өмнөх оноос 37016,1 мянган төгрөгөөр буюу 22,5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 37016,1 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 25598,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 6394,5 мянган төгрөгийн хөрөнгө, 5787,1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн авч тус тус нэмэгдсэн, 944,4 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого буурсан зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

Нийт зардал 189268,7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 24834,5 мянган төгрөгөөр буюу 15,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамжийн материал, урсгал засварын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 207043,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 207043,7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25361,2 мянган төгрөгөөр бууруулж 181682,5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 181682,5 мянган төгрөгийг батлагдсанаас 2 удаагийн зохицуулалт хийж 3278,0 мянган төгрөгөөр хасаж 178404,5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 178404,5 мянган, төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж урсгал үйл ажиллагааны зардлаас 28796,6 мянга, дотоод хяналтын тогтоосон актын төлбөр 223,9 мянган төгрөг нийт 29020,5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 149607,8 мянган төгрөг буюу 83,9 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 20995,0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж /гэрээт ажилтны цалин/ 7682,1 мянга, томилолтын зардал 78,0 мянга, шуудан холбооны зардал 41,8 мянга, тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 28796,6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний зардлыг 28796,6 мянган төгрөгөөр зарцуулаагүйтэй холбоотой байна.

Энэ нь 2 мэргэжилтний орон тоо сул, жирэмсэн амаржсаны чөлөөтэй 1 албан хаагч, гэрээт нягтлан бодогчийн цалинг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас бодож олгоогүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 714,2 мянга, засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 10000,0 мянга, ус рашааны дүгнэлтийн орлогоор 150,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ хуваарилсан.

Үүнээс Усны тооллогын зардалд 10000,0 мянга, байгаль орны хог хаягдал устгах зардал 778,0 мянган төгрөгийг зарцуулж, 86,2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого 188404,5 мянга, зарлагын 5600,0 мянга төгрөгийг тус тус мэдээлсэн.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуу лаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	0	2
2	Хагас жил	4	4	4	0		
3	Улирал бүр	1	4	4	0		
4	Сар бүр	3	36	36	0		
5	Тухай бүр	8	96	96	0		
6	Нийт	27	151	149	0	0	2

Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 932,3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

/Мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	932.3	2	932.3			
Нийт дүн	2	932.3	2	932.3			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23635,1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 124,8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3367,1 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 2314,0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 17829,2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Шатахууны картад худалдан авалтын хөнгөлөлтийн орлого 124,8 мянган төгрөгийг төвлөрснийг шатахууны орлого авхуулж үлдэгдлээр тусгаж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 23635,1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3367,1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2314,0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ Үүнд:

1. Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргаар Г.Хүрэлсүхийг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түр томилсон Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020.05.29 ний Б/34 тоот тушаалд зэрэг дэв, төрийн алба хаасны нэмэгдэл талаар тусгаагүй байхад нягтлан бодогч нийт 1088.7 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон ба үүнээс ажилтнаас суутгасан НДШ, ХАОАТ-ын хасаж тооцоход 867.1 мянган төгрөгийн илүү цалин олгож дээрх тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас 2500.0 мянган төгрөгийг 2020.12.18-ны өдөр Эх бүрдэн ХХК -ны дансанд проектор, зөөврийн компьютер худалдан авахаар нэхэмжлэлийн дагуу шилжүүлсэн боловч хөрөнгийг аваагүй, харин иргэн Н.Баянжаргалаас машины сэлбэг хэрэгсэл худалдан авсан гэж орлого авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14 ний өдрийн 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар” тус тус зөрчиж “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар олгосон 1959.5 мянган төгрөгийн өртөг бүхий "ZS200-6" мотоциклийн гаалийн бичиг баримтыг гээгдүүлсэн гэсэн шалтгаанаар тээврийн хэрэгслийн гэрчилгээ, номер аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна гэсэн заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Мэргэжилтэн Э.Жамцын 4-р сарын цалинг 354.5 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1003,7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал *данстай холбоотой асуудал*

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн дансаар хийсэн гүйлгээнээс 15127.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөр, томилолт, шуудан холбооны зардлын 50 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй ажил гүйлгээг нягтлан бодогч шууд зардлаар бүртгэсэн, нярвын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2 "журналд бичих", Санхүү, эдийн засгийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ийн мөнгөн хөрөнгийн бүртгэлийг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Холбогдох заавар, журмыг мөрдөөгүйгээс зардал буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үргүй зарцуулах

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ хийхгүй байх, нярвын тайлан анхан шатны баримтыг хянаж баталгаажуулж байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд шатахууны зардлаас автомашины сэлбэг 700.0 мянга, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны төлбөр 33.0 мянган төгрөгийг төлж, цалингийн зардлаас 207.0 мянган төгрөгийн томилолтыг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулж, дээрх зардлыг шатахуун, цалингийн зардлаар буруу тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14 ний өдрийн 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар” тус тус зөрчсөн байна.

2.3 Эрсдэл: Зардлыг холбогдох журмын дагуу зарцуулаагүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвтэй багтааж зардлыг ангилал зориулалтын дагуу зарцуулж, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 1698.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь 2016 онд хулгайд алдагдсан мотоцикл байна. Үүнийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулсан ба эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэр гаргасан тухай баримтыг байгууллагад хүргүүлсэн боловч зөрчлийг арилгаж хөрөнгийг данснаас хасаагүй байна.

Энэ нь (Оршин байх, Эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Эрсдэл: Хөрөнгө дутагдах, хөрөнгийн тооллогыг баталгаажуулаагүй байх

3.3 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1698,0 мянган төгрөгийн мотоциклийн асуудлыг холбогдох байгууллагуудад хандаж хууль тогтоомжийн дагуу хохирлыг төлүүлж, хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хөрөнгийн данс бүртгэлээс хасах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Орлогын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансаар өөрийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч ус рашаан ашигласны дүгнэлтийн орлого 150.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зөвшөөрөлгүй 63.7 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг зөрчсөн байна.

4.2 Эрсдэл: Батлагдсан төсөв хэтрэх, төсвийн орлогыг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулах.

4.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн жилийн дундуур орсон орлогыг зарцуулахдаа Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг мөрдөж, хууль журмын дагуу зөвшөөрөгдөөгүй орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.12.31	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/174/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргаар Г.Хүрэлсүхийг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түр томилсон Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020.05.29 ний Б/34 тоот тушаалд зэрэг дэв, төрийн алба хаасны нэмэгдэл талаар тусгаагүй байхад 867156 төгрөгийн нэмэгдэл цалин олгож тушаалыг зөрчсөн байна.	867.1	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
2	Тайлант онд багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас 2500.0 мянган төгрөгийг 2020.12.18-ны өдөр Эх бүрдэн ХХК -ны дансанд проектор, зөөврийн компьютер худалдан авахаар нэхэмжлэлийн дагуу шилжүүлсэн боловч хөрөнгийг аваагүй, харин иргэн Н.Баянжаргалаас машины сэлбэг хэрэгсэл худалдан авсан гэж орлого авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	2500,0	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
3	БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар олгосон 1959.5 мянган төгрөгийн өртөг бүхий "ZS200-6" мотоциклийн гаалийн бичиг баримтыг гээгдүүлсэн гэсэн шалтгаанаар тээврийн хэрэгслийн гэрчилгээ, номер аваагүй байна.	1959.5	Албан шаардлага	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
4	Мэргэжилтэн Э.Жамцын 4-р сарын цалинг 354.5 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	354.5	Албан шаардлага	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
5	Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн дансаар хийсэн гүйлгээнээс 15127.5 мянган төгрөгийн түрээсийн төлбөр, томилт, шуудан холбооны зардлын 50 гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн	15127,5	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

A	1	2	3	4	5
6	Шатахууны зардлаас автомашины сэлбэг 700.0 мянга, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны төлбөр 33.0 мянган төгрөгийг төлж, цалингийн зардлаас 207.0 мянган төгрөгийн томилолтыг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулж, дээрх зардлыг шатахуун, цалингийн зардлаар буруу тайланд тусгасан байна.	940,0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
7	Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 1698.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь 2016 онд хулгайд алдагдсан мотоцикл байна. Үүнийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулсан ба эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэр гаргасан тухай баримтыг байгууллагад хүргүүлсэн боловч зөрчлийг арилгаж хөрөнгийг данснаас хасаагүй байна.	1698,0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
8	Нэмэлт санхүүжилтийн дансаар өөрийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч ус рашаан ашигласны дүгнэлтийн орлого 150.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зөвшөөрөлгүй 63.7 мянган төгрөгийг зарцуулсан.	63.7	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
9	Шатахууны картад худалдан авалтын хөнгөлөлтийн орлого 124,8 мянган төгрөгийг төвлөрснийг санхүүгийн тайланд тусгаагүй.	124.8	Залруулга хийсэн	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Г.Хүрэлсүх, С.Мөнхбаатар
ДҮН		23635,1			

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.ГАНЧИМЭГ 2021.02.03

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АУДИТЫН МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ 2021.02.03

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.03